



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/205/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn  
Аудитор: П.Амарсанаа  
Утас: 260512 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Мэдээлэл аудит" ХХК  
Захирал: Д.Товуудорж  
Утас: 70159511 Цахим хаяг: medeeleaudit@gmail.com

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	16
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.6.3 Нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт .....	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.3 Зөвлөмж .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	<u>22</u>

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/346  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН  
ГАЛЕРЕЙН ЗАХИРАЛ Б.САРАНТУЯА  
ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын уран зургийн галерейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>89,668,296.69</b>	<b>106,052,430.39</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>7,675,354.69</b>	<b>7,271,154.69</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>7,675,354.69</b>	<b>7,271,154.69</b>
3351	Байгууллагаас авах авлага	404,200.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,271,154.69	7,271,154.69
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>81,992,942.00</b>	<b>98,781,275.70</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>420,000.00</b>	<b>420,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	420,000.00	420,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>81,572,942.00</b>	<b>98,361,275.70</b>
35410	Бичиг хэргийн материал	1,843,465.00	1,957,030.00
35420	Аж ахуйн материал	2,413,840.00	1,259,700.00
35440	Түлш, шатах тослох материал	212.00	284.00
35470	Бусад хангамжийн материал	77,315,425.00	95,144,261.70
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,364,737,782.58</b>	<b>15,573,236,138.97</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>15,364,737,782.58</b>	<b>15,573,236,138.97</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>15,364,067,990.98</b>	<b>15,572,591,347.43</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	72,144,671.75	44,765,719.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,303,940.60)	(27,998,876.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,157,703.41	76,240,061.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(54,359,771.61)	(34,423,167.56)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,301,294,792.00	15,511,708,044.00
39217	Ном	1,858,182.00	2,299,567.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>669,791.60</b>	<b>644,791.54</b>
39301	Програм хангамж	2,075,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,405,208.40)	(555,208.46)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>15,454,406,079.27</b>	<b>15,679,288,569.36</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,454,406,079.27</b>	<b>15,679,288,569.36</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>15,454,406,079.27</b>	<b>15,679,288,569.36</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	859,650,551.83	859,650,551.83
51101	Өмч: - төрийн	859,650,551.83	859,650,551.83
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>280,031,291.44</b>	<b>566,192,949.53</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	280,031,291.44	280,031,291.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	286,161,658.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,314,724,236.00	14,253,445,068.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>15,454,406,079.27</b>	<b>15,679,288,569.36</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>450,392,800.00</b>	<b>729,362,955.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,100,000.00</b>	<b>275,739,155.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	37,800,000.00	194,921,160.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		5,279,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		5,279,400.00
120009	Бусад орлого	37,800,000.00	189,641,760.09
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	300,000.00	80,817,995.00
122001	Хандив тусламж /дотоод/	300,000.00	80,817,995.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>412,292,800.00</b>	<b>453,623,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	381,687,300.00	366,096,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	381,687,300.00	366,096,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>30,605,500.00</b>	<b>87,527,000.00</b>
131103	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	6,125,000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	59,467,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,480,500.00	28,059,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>425,599,216.57</b>	<b>459,119,442.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>425,599,216.57</b>	<b>459,119,442.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	389,616,187.15	404,248,901.49
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	149,504,379.10	140,355,352.00
210101	Үндсэн цалин	115,899,147.10	108,906,564.00
210102	Нэмэгдэл	14,963,232.00	13,604,788.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,642,000.00	17,844,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,588,066.25	19,215,643.00
210201	Тэтгэврийн даатгал	13,638,080.39	13,619,662.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,604,576.43	1,516,031.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,108,223.65	1,122,104.82
210204	Ажилгүйдлийн даатгал	380,404.16	281,113.25
210205	Эрүүл мэндийн даатгал	2,856,781.62	2,676,731.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	126,225,000.00	126,225,000.00
210304	Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,145,331.82	32,363,391.91
210401	Бичиг хэрэг	2,570,530.00	5,293,805.00
210402	Тээвэр, шатахуун	1,230,490.00	888,928.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,990,196.82	2,449,785.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	905,600.00	525,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,448,515.00	23,205,873.39
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5,291,960.00	925,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,291,960.00	925,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,000,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	44,757,600.00	57,234,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,973,100.00	53,531,488.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,670,000.00	1,703,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,103,849.98	19,929,526.58

Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,463,849.98	19,929,526.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,983,029.42</b>	<b>54,870,541.48</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,655,529.42</b>	<b>54,870,541.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /урсгал/		33,929,041.48
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/		20,941,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>24,793,583.43</b>	<b>270,243,512.12</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		24,195,200.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		24,195,200.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		8,277,054.03
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		8,276,354.03
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		700.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		15,918,145.97
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>24,793,583.43</b>	<b>286,161,658.09</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.0	259,517,726.79	15,433,892,514.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(296,216.00)	(296,216.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.0	259,221,510.79	15,433,596,298.62
D07	Тайлант үеийн үр дүн			20,809,780.65	20,809,780.65
D08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	280,031,291.44	15,454,406,079.27
D10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	859,650,551.83	14,314,724,236.00	280,031,291.44	15,454,406,079.27
D11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(61,279,168.00)		(61,279,168.00)
D15	Тайлант үеийн үр дүн			286,161,658.09	286,161,658.09
D16	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	859,650,551.83	14,253,445,068.00	566,192,949.53	15,679,288,569.36



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>412,292,800.00</b>	<b>453,623,800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>412,292,800.00</b>	<b>453,623,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>381,687,300.00</b>	<b>366,096,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	381,687,300.00	366,096,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>30,605,500.00</b>	<b>87,527,000.00</b>
131103	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	6,125,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	59,467,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,480,500.00	28,059,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>412,017,887.00</b>	<b>434,821,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,017,887.00</b>	<b>434,821,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>376,034,857.58</b>	<b>379,950,758.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>149,701,441.00</b>	<b>140,355,352.00</b>
210101	Үндсэн цалин	106,330,776.00	108,906,564.00
210102	Нэмэгдэл	26,918,665.00	13,604,788.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,452,000.00	17,844,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,718,654.76</b>	<b>19,215,643.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,709,836.76	13,632,262.13
210202	Тэтгэмжийн даатгал	1,562,519.38	1,516,031.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,258,970.09	1,122,104.82
210204	Ажилгүйдлийн даатгал	287,362.75	276,913.25
210205	Эрүүл мэндийн даатгал	2,899,965.78	2,668,331.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>126,225,000.00</b>	<b>126,225,000.00</b>
210304	Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,567,848.82</b>	<b>7,783,839.52</b>
210401	Бичиг хэрэг	3,593,700.00	1,927,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,230,500.00	889,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,569,843.82	2,252,239.52
210404	Ном хэвлэл	400,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	605,600.00	1,472,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,168,205.00	1,243,000.00
2105	Нормативт зардал	1,236,960.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>61,584,953.00</b>	<b>78,370,924.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,752,669.00	74,667,424.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,717,784.00	1,703,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,983,029.42</b>	<b>54,870,541.48</b>
	Бусад урсгал шилжүүлэг	14,327,500.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,655,529.42</b>	<b>54,870,541.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг /Урсгал /	21,655,529.42	33,929,041.48
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/		20,941,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>274,913.00</b>	<b>18,802,500.00</b>

Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>275,000.00</b>	<b>18,802,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>275,000.00</b>	<b>18,802,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>275,000.00</b>	<b>18,802,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	275,000.00	18,802,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(275,000.00)</b>	<b>(18,802,500.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>366,096,800.00</b>	<b>332,167,758.52</b>	<b>(33,929,041.48)</b>	<b>90.7</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>366,096,800.00</b>	<b>332,167,758.52</b>	<b>(33,929,041.48)</b>	<b>90.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	365,768,800.00	332,167,758.52	(33,601,041.48)	90.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	168,156,500.00	140,355,352.00	(27,801,148.00)	83.5
210101	Үндсэн цалин	109,506,400.00	108,906,564.00	(599,836.00)	99.5
210102	Нэмэгдэл	42,270,100.00	13,604,788.00	(28,665,312.00)	32.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,380,000.00	17,844,000.00	1,464,000.00	108.9
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,701,200.00</b>	<b>19,215,643.00</b>	<b>(3,485,557.00)</b>	<b>84.6</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,974,900.00	13,632,262.13	(2,342,637.87)	85.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,681,600.00	1,516,031.12	(165,568.88)	90.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,345,300.00	1,122,104.82	(223,195.18)	83.4
210204	Ажилгүйдлийн даатгал	336,300.00	276,913.25	(59,386.75)	82.3
210205	Эрүүл мэндийн даатгал	3,363,100.00	2,668,331.68	(694,768.32)	79.3
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>126,225,000.00</b>	<b>126,225,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	126,225,000.00	126,225,000.00	00.00	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,541,700.00</b>	<b>7,533,839.52</b>	<b>(7,860.48)</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	1,928,400.00	1,927,600.00	(800.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	889,000.00	889,000.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,228,400.00	2,252,239.52	23,839.52	101.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,502,400.00	1,472,000.00	(30,400.00)	98.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	993,500.00	993,000.00	(500.00)	99.9
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,944,400.00</b>	<b>38,837,924.00</b>	<b>(2,106,476.00)</b>	<b>94.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,905,900.00	36,134,424.00	(1,771,476.00)	95.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	104,000.00	00.00	(104,000.00)	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,500.00	00.00	(114,500.00)	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00	(20,000.00)	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000.00	1,703,500.00	(96,500.00)	94.6
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>200000.00</b>	<b>0.00</b>	<b>(200,000.00)</b>	<b>0.0</b>
210901	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	00.00	(200,000.00)	0.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>328000.00</b>	<b>0.00</b>	<b>(328,000.00)</b>	<b>0.0</b>

Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>328,000.00</b>	<b>00.00</b>	<b>(328,000.00)</b>	<b>0.0</b>
213209	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	328,000.00	00.00	(328,000.00)	0.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>366,096,800.00</b>	<b>332,167,758.52</b>	<b>(33,929,041.48)</b>	<b>90.7</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>366,096,800.00</b>	<b>332,167,758.52</b>	<b>(33,929,041.48)</b>	<b>90.7</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	366,096,800.00	<b>332,167,758.52</b>	<b>(33,929,041.48)</b>	<b>90.7</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	13	13	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>87,527,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>87,527,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>66,585,500.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>250,000.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар		8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>58,335,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		57,335,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>20,941,500.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		20,941,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>87,527,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>87,527,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		59,467,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		28,059,500.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 21-ний хооронд Мэдээлэл-Аудит ХХК-ийн аудитор Н.Ганданбаавар, аудитор Д.Туяа, аудиторын туслах Ц.Отгонжаргал нар хэрэгжүүлж, хяналтыг чанарын хяналтын менежер С.Адьяахүү, захирал Д.Товуудорж нар хэрэгжүүлсэн.

Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монголын уран зургийн галерей нь орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдтэй олон түмнийг танилцуулах, дүрслэх урлагаар дамжуулан үзэгчдэд гоо зүйн болон урлагийн боловсрол олгох,
- 1921 оны Ардын Хувьсгал ялснаас хойш өнөөдрийг хүртэлх үе үеийн авьяаслаг уран бүтээлчдийн бүтээсэн уран зураг, уран баримал, уран сийлбэр, хөөмөл, хатгамал, зээгт наамал, өрөг урлал гээд дүрслэх урлагийн бүхий л төрлийн 4000 гаруй бүтээл тус галерейд хадгалагдаж байна. Жил бүр дүрслэх урлагийн шилдэг бүтээлээр сан хөмрөгөө баяжуулж, судлан сурталчилж, хадгалж хамгаалан олон түмэнд дэлгэн толилуулдаг.
- Монголын уран зургийн уламжлал, дэг жаягийн давтагдашгүй онцлогийг шингээсэн орчин үеийн бүтээлийг олон улсад таниулж, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц бүтээлч орчин бүрдүүлэх, түүхийн дурсгалт бүтээлүүдийн хадгалалт хамгаалалтыг олон улсын жишигт хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг 190 дүгээр тушаалын хавсралт;



- Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Музейн тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх;
- Соёлын тухай хууль 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Соёлын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Монголын уран зургийн галерейн 2021 оны шилэн дансны хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын дүгнэлтээр 94.6 хувь буюу “Хангалттай” гэж үнэлгээ өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

### **3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын зардлын 425,599.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,647.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Монголын уран зургийн галерейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 224,882.5 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс**нууд** байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	7,675.3	7,271.1	(404.2)
Бараа материал	81,992.9	98,781.3	16,788.4
Үндсэн хөрөнгө	15,364,737.8	15,573,236.1	208,498.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>15,454,406.1</b>	<b>15,679,288.6</b>	<b>224,882.5</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,454,406.1	15,679,288.6	224,882.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>15,454,406.1</b>	<b>15,679,288.6</b>	<b>224,882.5</b>

Авлага дансны үлдэгдэл 7,271.1 мянган төгрөг болж 404.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн 404.2 төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 2009-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 7,271.1 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 98,781.3 мянган төгрөг болж 16,788.4 мянган төгрөгөөр өссөн нь Соёлын бүтээлч үйлдвэрлэлээр Азарганы ноцолдоон пазлыг Таван нүдэн ХХК-тай хамтран бүтээсэн, Дүрслэх урлагийн академитай хамтран Соцреализм монголын дүрслэх урлагт судалгааны эмхэтгэл номыг Мөнхийн үсэг ХХК-иар хэвлүүлж орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 15,573,236.1 мянган төгрөг болж 208,498.3 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн нэмэлт орлогын эх үүсвэрээр болон хандиваар, үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан зэргээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 18,802.5 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2021 оны 280 дугаар тогтоолоор 24,195.2 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2021 оны 11 сарын 22-ны А-1/1917 дугаар албан бичгээр 172,641.7 мянган төгрөг, 2021 онд улсын санд бэлэг хандиваар бүртгэн авсан үзмэр эд өлгийн 40 нэрийн зүйлийг Монголын уран зургийн галерейн захирлын 2021 оны А/11 дугаар тушаалаар үнэлэн 80,690.2 мянган төгрөг хөрөнгөөр үнэлэн бүртгэж, элэгдлийн зардал 19,929.5 мянган төгрөгөөр буурсан байна.

ТӨБЗГ-ын 2021 оны А/1/1032 дугаар албан бичгийн дагуу 2,929.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, ТӨБЗГ-ын 2021 оны 280 дугаар тогтоолоор Монголын уран зургийн галерейн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 47 нэрийн 70,021.2 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 24,195.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 644.7 мянган төгрөг болж 25.0 мянган төгрөгөөр буурсан нь урсгал төсвийн худалдан авалтаар 275.0 мянган төгрөгөөр өссөн, тайлант хугацааны хорогдлын зардал 300.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,679,288.6 мянган төгрөг болж 224,882.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 286,161.6 мянган төгрөгөөр өсөж, дахин үнэлгээний зөрүү 61,279.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 278,970.2 мянган төгрөгөөр буюу 62 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 5,279.4 мянган төгрөг, улсын санд бэлэг хандиваар авсан 80,817.9 мянган төгрөг, бусад 189,641.7 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 28,059.5 мянган төгрөг байна.

Нийт зардал өмнөх оноос 33,520.3 мянган төгрөгөөр буюу 8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ТӨБЗГ-ын 2021 оны А/1/1032 дугаар албан бичгийн дагуу 6,012.5 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл акталж, улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг 33,215.0 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 861,679.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 861,679.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 495,582.6 мянган төгрөгөөр бууруулж 366,096.8 мянган төгрөгөөр баталсан байна. Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, өргөжүүлэх, олон улсын галерейн жишигт хүргэхийн тулд "Музейд заавал шаардлагатай жишиг" MNS 5634:2006 стандартад заасан галерейд зайлшгүй шаардлагатай байгаа куратор, тайлбарлагч, сэргээн засварлагч, урлагийн боловсролын ажилтан, эрдэм шинжилгээний ажилтнаар орон тоогоо нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа мөн галерейн сан хөмрөгүүдэд хадгалагдаж буй түүх соёлын үнэт өв болох бүтээлүүдийн хадгалалт, хамгаалалтын орчин нөхцөлийг сайжруулах зэрэг байгууллагад тулгамдаж буй асуудлуудыг төсвийн төсөл, төсөөлөлд тусгаж боловсруулсныг Ковид 19 цар тахалтай холбоотойгоор хойшлогдож төсвийн төслөөс буурч батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 366,096.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 366,096.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 366,086.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 332,167.8 мянган төгрөгийг зарцуулж 33,929.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 332,167.8 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 27,801.1 мянган төгрөгөөр, ажил

олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,485.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 2,106.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 33,929.0 мянган төгрөгөөр буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшууллаас 27,801.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 2,106.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 3,485.5 мянган төгрөгийг тус тус хэмнэн зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71702	Соёл урлаг	366,096.8	332,167.8	33,929.0	90.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	346,896.8	312,967.8	33,929.0	90.2
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	19,200.0	19,200.0		100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 59,467.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,059.5 мянган төгрөг, нийт 87,527.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа, материалын зардалд 250.0 мянган төгрөг, урсгал засварт 8,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 58,335.5 мянган төгрөг, нийт 66,585.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 20,941.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа болон бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт ороогүй. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 572,839.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 5 мэдээллийн хугацаа болоогүй, 37,000.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй боловч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмжийн зардлаас бусад зардлын батлагдсан төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтээр шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй боловч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмжийн зардлаас

бусад зардлын батлагдсан төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Түүх соёл, музейн дурсгалт зүйлс дансанд бүртгэлтэй байгаа үзмэрүүдийг 2014 онд дахин үнэлсэн ба уг дахин үнэлгээг 21 гэсэн нэрээр "Дахин үнэлгээ" гэсэн хөрөнгө үүсгэн бөөн дүнгээр бүртгэсэн байсныг хөрөнгө тус бүрээр салгаж бүртгэх, Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн Регистер программд 3659 ширхэг 15,073,161.4 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бол санхүүгийн тайлангаар 3.366 ширхэг 15,249,905.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрүүг арилгах талаар өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй байгаа талаар завсрын аудитаар 2 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 4 мэдээлэл хоцроож алдаа зөрчлийг давтан гаргасан байна. Аудитаар өгсөн 2,257.1 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3		2		1		99.1
Зөвлөмж	4	2,257.1	4	2,257.1			100
Нийт дүн	7	2,257.1	6	2,257.1	1		99.5

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагын хэрэгжүүлээгүй, тайлант онд дахин 4 мэдээлэл хоцроосонд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Монголын уран зургийн галерейн 2021 оны 11 дүгээр сарын 03-ний өдрийн 132 дугаар албан бичгээр Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн зарчмаар галд өртсөн, Их тэнгэр цогцолборт байдаг 34 бүтээл зэрэг 236 нэрийн бүтээлийн өртгийг 0 өртөгтэйгөөр регистр программд бүртгэсэн боловч санхүүгийн бүртгэлд 122,403.9 мянган төгрөгийг өртөгтэй байгааг хасалт хийж актлах талаар албан бичгийг ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч холбогдох мэргэжлийн байгууллагын акт дүгнэлт зэрэг баримтын бүрдлийг ханган дахин санал ирүүлэх талаар ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А-1/2028 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн байна. Иймд эдгээр бүтээлийг хэрхэн шийдвэрлүүлэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.



#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс 18.0 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчил бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 6,647.6 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 2021 оны бэлэн хүлээн авсан үзвэр үйлчилгээний орлогыг кассанд тушаасан шимтгэлийн зардал 18.0 мянган төгрөгөөр хасаж тайлагнасныг залруулав.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. *Анхан шатны баримттай холбоотой асуудал*

###### 1.1 Илрүүлэлт:

Холбогдох анхан шатны баримт бүрдүүлсэн боловч харилцагч байгууллагаар и-баримт шивэгдээгүй гүйлгээ байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээ гарсан тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Уран зургийн галерей	АХГ-2022/205/НА-СТА-ТШЗ	Ажил гүйлгээ нь холбогдох бусад анхан шатны баримт бүрдүүлсэн боловч и-баримтаар баталгаажуулах гүйлгээ байна.	Ажил гүйлгээ гарсан тухай бүр гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах зөвлөж өгсөн.	1								1	
2	Уран зургийн галерей	АХГ-2022/205/НА-СТА-ТШЗ	2021 оны бэлэн хүлээн авсан үзвэр үйлчилгээний орлогыг кассанд тушаасан шимтгэлийн зардал 18.0 мянган төгрөгөөр хасаж цэвэршүүлэн тайлагнасан	Санхүүгийн үр дүнгийн тайланд 18.0 мянган төгрөгийн залруулга хийж Санхүүгийн тайланг зассан.	1	18.0	1	18.0						
<b>ДҮН</b>					2	18.0	1	18.0					1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
2	Уран зургийн галерей	АХГ-2022/205/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 37,000.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	Зөрчлийг бүрэн арилгах, давтан гаргахгүй байх удирдлагад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.	1	37,000.0					1	37,000.0		
<b>ДҮН</b>					1	37,000.0					1	37,000.0		
<b>НИЙТ ДҮН</b>					3	37,018.0	1	18.0			1	37,000.0	1	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 264/А0150458  
АХГ-2022/205/НА-СТА-ТМС

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 37,000,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний 4 мэдээлэл хоцроож байршуулсан алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8."бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын уран зургийн галерейн захирал Б.Сарантуяад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Д.ТОВУУДОРЖ



